

УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

| | |
|---|--|
| Хянасан огноо | |
| Хянасан мэргэжилтэнгүүдийн хувийн дугаар | |
| Дүгнэлт <ul style="list-style-type: none"> • Шийдвэрийн төсөл • Ололт, амжилттай тал • Дутагдалтай сул тал • Шаардлага | |

НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамаарахгүй хэсгийг “*хамааралгүй*” гэж бөглөх.
- 1.2.7 дах хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

| № | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах багана |
|-----|--|--|
| 1.1 | 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр | “Багатаян” ХХК |
| | 2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар | 9011082149 |
| | 3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл | Гадаад худалдаа, Хүнсний дэлгүүр |
| | 4. Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг | УБ хот, БЗД, 17-р хороо, Шар хад, Да хүрээ захын зүүн талд, 55257057 |
| | 5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг | М.Болдбаатар, 99112775 |
| | 6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг | Д.Даваадорж, 99825925 Ddorj825925@yahoo.com |
| 1.2 | 1. Төслийн нэр | Хавчуугийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах |
| | 2. Төслийн харъяаллын байршил | Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт Хавчуу хэмээх газар |

| | |
|--|--|
| <p>3. Төслийн ангилал</p> <ul style="list-style-type: none"> а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт б. ил уурхай, далд уурхай, шороон орд с. баяжуулах үйлдвэр | <ul style="list-style-type: none"> а. Алт б. Ил уурхай |
| <p>4. Төсөл эхэлсэн огноо</p> | <p>2019-05-12</p> |
| <p>5. Төсөл хэрэгжих хугацаа</p> | <p>5 жил</p> |
| <p>6. Уурхайн хаалт эхлэх огноо</p> | <p>2022 он</p> |
| <p>7. Хаалтын дараах зориулалт</p> | <p>Хөдөө аж ахуй</p> |
| <p>8. ТЭЗҮ баталсан огноо</p> | <p>2018-10-04</p> |
| <p>9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/</p> | <p>12.25 кг</p> |
| <p>10. Ажилчдын тоо</p> | <p>50</p> |
| <p>11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө</p> | <p>2024 онд манай компани С₁-16-р блокын нөөцийг бүрэн ашиглаж 14.5 мян.м³ элс угааж 6.72 кг цэвэр алт олборлохоор төлөвлөж байна.</p> |
| <p>12. Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц</p> <ul style="list-style-type: none"> • Замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл • Шатахуун түгээгүүрийн тоо • Шатахууны агуулахын агууламжийн хэмжээ • Тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт | <ul style="list-style-type: none"> • Уурхайн дотоод замын урт-1.2км /уурхайн ам-уурхайн кемп/ • ШТМ-20тн-ы ёмкость |

**ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын нөөц, ТЭЗҮ баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

| № | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах багана | | |
|---|--|---|---------------------------|---------|
| 2.1 | 1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа Талбай | Дугаар: MV-000150 Хүчинтэй хугацаа: 30 жил Талбай: 71.76 га | | |
| | 2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа | Хамааралгүй | | |
| | 3. Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт | Хамааралгүй | | |
| | 4. Галын дүгнэлтийн огноо, дугаар | | | |
| | 5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд | 2019.02.04 | | |
| | 6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд | 2019 он | | |
| | 7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо | | | |
| | 8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо | 2022-04-26 | | |
| | 9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах | Хавсаргав | | |
| | 10. Нөхөн сэргээлт | Техникийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/ | Тайлант онд гүйцэтгэсэн | 12.0 га |
| | | | Төлөвлөгөөт онд гүйцэтгэх | 9.0 га |
| Биологийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/ | | Тайлант онд гүйцэтгэсэн | 1.0 га | |
| | | Төлөвлөгөөт онд гүйцэтгэх | 12.0 га | |
| 11. ТХГН-ын тухай хууль, гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн | | Хавсаргасан | | |

| | |
|---|--|
| хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах | |
|---|--|

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтанд тусгагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заасны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох мэдээллийг доорх хүснэгтэд оруулах
- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд химийн бодисын хор, аюул, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хавсралтаар оруулж, доорх хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах (хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай)
- Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт “хангалттай” гэсэн дүгнэлтийг оруулна.

| № | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах хэсэг |
|------|--|--|
| 3.1 | 1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/ | Хамааралгүй |
| | 2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө <ul style="list-style-type: none"> - Урьдчилан сэргийлэх арга хэмжээ - Эрсдэлийн үед авах арга хэмжээ - Учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ - Хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ | Хамааралгүй |
| 3.2 | 1. Шатах тослох материалын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх | 1. Шатах тослох материал: 3 төрөл, 90.0 тонн 2. Хамааралгүй |
| 3.3. | 1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ <ul style="list-style-type: none"> • Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ • Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ • Аюултай хог хаягдал | <ul style="list-style-type: none"> • Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ - 4.0 тн • Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ - 1.8 тонн • Аюултай хог хаягдал – аккумулятор - 4.5 ш, фильтр (агаар/тосны) - 13ш • Хаягдал дугуй – 20 ш |

| | |
|---|-------------|
| 2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв | 1.0 сая.төг |
|---|-------------|

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

- Доорх хүснэгтийн 4.1.2 - 4.1.7 –д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 –д тусгагдана.

| № | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах хэсэг |
|-----|--|------------------------|
| 4.1 | 1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв | 9 040.0 |
| | 2. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/ | 2 000.0 |
| | 3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв | 4 500.0 |
| | 4. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/ | 189 540.0 (ҮАЗ) |
| | 5. Дүйцүүлэн хамгаалал, Тэр бум мод тарих хөдөлгөөн | 10 000.0(ҮАЗ) |
| | 6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв | 1 240.0 |
| | 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх (хог хаягдал) | 1 300.0 |
| | 8. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв | |
| | 9. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв | 10 000.0(ҮАЗ) |

ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг байгаль орчны мэдээллийн санд оруулна.
- Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

| № | Мэдээллийн төрөл | Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах хэсэг |
|-----|---|--|
| 5.1 | Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл | |
| | Тосгон | + |
| | Хог хаягдлын цэгийн байршил | + |
| | Аюултай хог хаягдлын агуулахын байршил | |
| | Хаягдлын далан | + |
| | Химийн бодисын агуулахын байршил | |
| | Орчны хяналт шинжилгээний дээж авах | + |
| | Хяналтын цэгийн байршил | + |
| | Тухайн жилд хуулах хөрс | + |
| | Гадаад, дотоод овоолго | |
| | Техникийн нөхөн сэргээлтийн талбай | + |
| | Биологийн нөхөн сэргээлтийн талбай | + |
| | Гүний худгийн байршил | |
| | Дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршил | |

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэх багананд “тодорхойлсон”, “тодорхойлоогүй”, “хамааралгүй” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- Дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтэн дүгнэлт гаргана.

| Нөлөөллийн ангилал | А. Тооцсон эсэх | Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх | В. Нөлөөл-лийн эрчмийг тодорхойлсон эсэх | Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх | Дүгнэлт |
|---|-----------------------|--|--|---|---------|
| 6.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Эвдэх - Доройтуулах | тодорхойлсон | тодорхойлсон | тодорхойлсон | тодорхойлсон | |
| 6.2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Нөөцийг бууруулах | тодорхойлсон | тодорхойлсон | тодорхойлсон | тодорхойлсон | |
| 6.3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл - амьдрах орчинг хуваах - амьдрах орчинг доройтуулах - амьдрах орчинг хомсдуулах - нөөцийг бууруулах | тодорхойлсон | тодорхойлсон | тодорхойлсон | тодорхойлсон | |
| 6.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - тоос | тодорхойлсон | тодорхойлсон | тодорхойлсон | тодорхойлсон | |
| 6.5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс - Хамгаалах - Нүүлгэн шилжүүлэх | Хамааралгүй | Хамааралгүй | Хамааралгүй | Хамааралгүй | |

ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “**тийм**”, “**үгүй**” хариулт өгнө.
- Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтнүүд “**хангалттай**” “**хангалтгүй**” гэсэн дүгнэлт өгнө.

| Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл | А. Тоо | Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх | В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх | Г. Дүгнэлт |
|---|----------------------------|--|---|---------------|
| 7.1.Нөлөөллөөс урьдчлан сэргийлэх зайлуулах арга хэмжээ | 1 | Тийм | Тийм | |
| 7.2.Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | 4 | Тийм | Тийм | |
| 7.3.Нөхөн сэргээлтийн арга хэмжээ <ul style="list-style-type: none"> • Техникийн, га • биологийн, га | Тех- 6.7 га Био- 5.3 га | Үгүй | Үгүй | |
| 7.4.Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ | 1 | Тийм | Тийм | |
| 7.5.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ | 3 | Тийм | Үгүй | |
| 7.6.Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ | - | - | - | |
| 7.7.Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ | 1 | Үгүй | Үгүй | |

**НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

| Хяналт шинжилгээний дээж | А. Дээж авах цэгийн тоо | Б. Дээж авах цэгийн байршил | В. Давтамж (удаа) | Г. Төсөв (сая.төг) |
|--------------------------|-------------------------|---|-------------------|--------------------|
| 1. Хөрс | 4 | - Нөлөөлөлд өртөөгүй талбай - Нөхөн сэргээлт хийгдсэн талбай, - Шатахуун ачих, буулгах, машин механизмыг шатахуунаар цэнэглэх талбай, агуулах орчимд - Хог хаягдал бохирын цэгийн орчимд | 2 удаа | 2.0 |
| 2. Ус | 2 | - Тунгаах нуур - Хавчуугийн гол | 2 удаа | 2.0 |
| 3. Агаар | 2 | - Элс угаах төхөөрөмжийн орчимд, - Замын хажууд | 2 удаа | 2.0 |

ТОВЪЁОГ

| | |
|---|-------------------------------------|
| БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..... | 3 |
| 1.1. НЭР | ТӨСЛИЙН 3 |
| 1.1.1. Ашигт малтмалын дугаар..... | 3 |
| 1.1.2. Төсөл хэрэгжүүлэгч | 3 |
| 1.1.3. Төслийн байршил | 3 |
| 1.1.4. Ордын нөөцийн тооцоо | 5 |
| 1.1.5. 2024 онд ашиглах нөөц | Error! Bookmark not defined. |
| 1.2. ИЛ УУРХАЙ | 7 |
| 1.2.1. Үйлдвэрлэлийн нөөц | 7 |
| 1.2.2. Уурхайн ашиглалт..... | 7 |
| 1.2.3. Тоног төхөөрөмж..... | 9 |
| 1.2.4. Ухаж ачих, тээвэрлэх процесс | Error! Bookmark not defined. |
| 1.2.5. Уурхайн дотоод тээвэр..... | 9 |
| 1.2.6. Овоолгын аж ахуй..... | 10 |
| 1.3. БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ | 11 |
| 1.3.1. Баяжуулалтын технологи болон 2024 оны үйл ажиллагааны бүтээгдэхүүн гаргалт..... | 11 |
| 1.4. ДЭД БҮТЭЦ | 12 |
| 1.4.1. Уурхайн хотхон | 12 |
| 1.5. 2024 онд хийгдэх ажлын хэмжээ | 13 |
| БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..... | 14 |
| 2.1. Цаг уур, уур амьсгалын үзүүлэлтүүд | 14 |
| 2.2. Газрын гадарга, хэвлийн тогтоц, онцлог | 16 |
| 2.2.1. Геологийн тогтоц, давхрага зүй | 16 |
| 2.2.2. Геоморфологи..... | 16 |
| 2.2.3. Тектоник | 16 |
| 2.3. Усан орчин | 17 |
| 2.3.1. Гадаргын ус..... | 17 |
| 2.3.2. Гидрогеологи..... | 18 |
| 2.4. Хөрсөн бүрхэвч | 19 |
| 2.5. Ургамлан нөмрөг | 19 |
| 2.6. Амьтны аймаг | 20 |
| 2.7. Тусгай хамгаалалттай газар нутгууд | 21 |
| 2.8. Дархан-уул аймгийн Шарынгол сумын нийгэм эдийн засгийн хөгжил, онцлог | 22 |
| БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ..... | 23 |
| БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ..... | 25 |
| БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ | 26 |
| 5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 26 |
| 5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 30 |
| 5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, Тэрбум мод тарих | 30 |

**“Хавчуугийн алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө
/MV-000150/**

| | |
|--|----|
| 5.4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | 31 |
| 5.5.Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 31 |
| 5.6.Химийн бодис, Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 32 |
| 5.7.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 34 |
| 5.8.Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр | 36 |
| 5.9.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 40 |
| 5.10.Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь | 41 |
| 5.11.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал | 42 |

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН НЭР

“Хавчуугийн алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах

1.1.1. Ашигт малтмалын дугаар

MV-000150, (S=71.76 га)

1.1.2. Төсөл хэрэгжүүлэгч

Төсөл хэрэгжүүлэгч: “Багатаян” ХХК,

- Регистрийн дугаар: 2099551;
- Улсын бүртгэлийн дугаар: 9011082149;
- УБ хот, Баянзүрх, 17-р хороо, Шар хадны, Да хүрээ захын зүүн талд-1;
- Утас: 99099506, 99825925

1.1.3. Төслийн байршил

Хавчуу голын алтны шороон орд нь Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун хойш 210 км, Дархан-Уул аймгаас 70 км зайтай. Хавчуу голын алтны шороон орд нь нүүрсний уурхайн тосгоны төвөөс 7 км зайтай оршино.

Төсөл хэрэгжих MV-000150 тоот АМТЗ-ийн талбай нь М-48-105 хавтгайд байрлах бөгөөд талбайн үнэмлэхүй өндөр 920м байна.


Хүснэгт 1 Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл

| № | Уртраг | | | Өргөрөг | | |
|----|--------|-------|--------|---------|-------|--------|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 106 | 29 | 22.24 | 49 | 15 | 33.34 |
| 2 | 106 | 29 | 21.29 | 49 | 15 | 2.11 |
| 3 | 106 | 29 | 28.71 | 49 | 15 | 2.03 |
| 4 | 106 | 29 | 28.02 | 49 | 14 | 39.38 |
| 5 | 106 | 29 | 20.61 | 49 | 14 | 39.48 |
| 6 | 106 | 29 | 20.32 | 49 | 14 | 29.77 |
| 7 | 106 | 29 | 17.85 | 49 | 14 | 29.81 |
| 8 | 106 | 29 | 17.65 | 49 | 14 | 23.33 |
| 9 | 106 | 29 | 10.24 | 49 | 14 | 23.42 |
| 10 | 106 | 29 | 10.24 | 49 | 14 | 23.41 |
| 11 | 106 | 29 | 9.95 | 49 | 14 | 13.7 |
| 12 | 106 | 29 | 0.06 | 49 | 14 | 13.84 |
| 13 | 106 | 29 | 0.34 | 49 | 14 | 23.16 |
| 14 | 106 | 29 | 4.92 | 49 | 14 | 25.12 |
| 15 | 106 | 29 | 6.06 | 49 | 14 | 26.08 |
| 16 | 106 | 29 | 7.2 | 49 | 14 | 30.17 |
| 17 | 106 | 29 | 6.94 | 49 | 14 | 33.43 |
| 18 | 106 | 29 | 5.09 | 49 | 14 | 39.88 |
| 19 | 106 | 29 | 4.25 | 49 | 14 | 46.51 |

“Хавчуугийн алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө
/MV-000150/

| | | | | | | |
|----|-----|----|-------|----|----|-------|
| 20 | 106 | 29 | 4.21 | 49 | 14 | 52.98 |
| 21 | 106 | 29 | 5.07 | 49 | 15 | 0.3 |
| 22 | 106 | 29 | 5.07 | 49 | 15 | 0.31 |
| 23 | 106 | 29 | 6.02 | 49 | 15 | 2.31 |
| 24 | 106 | 29 | 6.46 | 49 | 15 | 2.3 |
| 25 | 106 | 29 | 6.49 | 49 | 15 | 3.32 |
| 26 | 106 | 29 | 8.99 | 49 | 15 | 8.62 |
| 27 | 106 | 29 | 9.18 | 49 | 15 | 17.78 |
| 28 | 106 | 29 | 9.24 | 49 | 15 | 21.6 |
| 29 | 106 | 29 | 13.73 | 49 | 15 | 23.33 |
| 30 | 106 | 29 | 19.4 | 49 | 15 | 27.82 |
| 31 | 106 | 29 | 20.44 | 49 | 15 | 28.36 |
| 32 | 106 | 29 | 22.08 | 49 | 15 | 33.2 |

Тусгай зөвшөөрлийн талбайн байршлын тойм зураг



Ашиглалтын талбайн одоогийн байдал (Photo by Phantom pro V.2.0)



Уурхайн тосгон (Photo by Phantom pro V.2.0)



1.1.4. Ордын нөөцийн тооцоо

Хавчуугийн алтны шороон ордод 1982 оноос эхлэн хайгуул хийгдэж эхэлсэн ба 1989 онд БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн дэргэдэх улсын ашигт малтмалын нөөцийн комиссын техникийн зөвлөлийн хурлаар дараах нөөцийг батлуулсан байна.

Хүснэгт 2 Нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

**“Хавчуугийн алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө
/MV-000150/**

| Блокын дугаар | Элсний зузаан, м | Эзэлхүүн мян.м3 | Алны агуулга гр/м³ | Алтны хэмжээ, кг |
|----------------------|-------------------------|------------------------|--------------------------------------|-------------------------|
| C1-1 | 1.4 | 11.2 | 0.96 | 11 |
| C1-2 | 1.6 | 19.5 | 0.9 | 17.5 |
| C1-3 | 1.3 | 13.6 | 0.95 | 12.9 |
| C1-4 | 1.8 | 26.6 | 0.89 | 23.6 |
| C1-5 | 2.3 | 42.3 | 0.95 | 40.1 |
| C1-6 | 2.1 | 53.3 | 1.11 | 59.3 |
| C1-7 | 2.1 | 73.2 | 1.22 | 89.1 |
| C1-8 | 2.4 | 66.7 | 1.32 | 88 |
| C1-9 | 2.5 | 93 | 1.28 | 118.6 |
| C1-10 | 1.9 | 50.7 | 1.07 | 54.2 |
| C1-11 | 1.4 | 35 | 0.91 | 31.7 |
| C1-12 | 1.3 | 6.1 | 0.92 | 5.6 |
| Нийт | 1.84 | 491.2 | 1.04 | 551.6 |

Хавчуугийн ордод хийсэн хайгуулын ажлын үр дүнд үндэслэн 551.6 кг алтны нөөцийг батлуулсан ба 1993 оноос Монгол Чехословак Металл ХХК тус ордод ашиглалт явуулж эхэлсэн. 1996 оны 01 сарын 04 ны өдрийн Эрчим хүч, геологи уул уурхайн сайдын тушаалаар 059 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Чехословак Металл ХХК-д өгсөн бөгөөд 1997 онд 150А нэртэйгээр шинчлэн бүртгэгдсэн.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших Хавчуугийн алтны шороо ордыг 2012 оны 8-р сарын 07-ний өдрийн №ХХ-16 тоот дүгнэлтээр "Гол мөрний урсац, бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сангийн газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль"-иар нөөцийн хасалтийг хийлгэж тухай үед ТЭЗҮ-ийн тодотголыг Перфектквалити" ХХК хийж гүйцэтгэсэн байдаг.

2017 онд Хавчуугийн голын гольдролд өөрчлөлт орсоноор Багатаян ХХК-нь онцгой хамгаалалтын 50м бүсийг Байгаль орчин, ногоон хөгжлийн яам/хуучин нэрээр/-д хүсэлт тавьсанаар шинэчлэн тогтоосон байдаг. Тухайн үеийн C1-1, C1-2, C1-3, C1-11 гэсэн 4 блокуудад олборлолт явах хууль эрх зүйн үндэс бий болсон.

2017 онд усны сан бүхий талбайн хамгаалалтын бүсийн зурвасыг шинээр тогтоосноор тусгай зөвшөөрлийн талбай 71.76 гектар болж өөрчлөгдсөн.

2020 оны эхэнд “Хавчуу”-гийн ордод БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын ашигт малтмалын нөөцийн комиссын хурлын 1989 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны №02 тоот тогтоолоор хүлээн авсан нөөцөөс MV-000150 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь 2-C₁ блокоос 9.8 кг нөөц, 3-C₁ блок бүхэлдээ буюу 12.9 кг нөөц мөн 4-C₁,12-C₁,15-C₁,16-C₁ блокууд олборлогдоогүй хөрсний овоолго дор үлдсэн нь маркшейдерийн хэмжилтээр тогтоогдсоноор ордын хэмжээнд, ашиглалтын тусгай зөвшөөрөл дотор 740.6 мг.м³-ийн дундаж агуулгатай 61.5 мян.м³ элсэнд химийн цэврээр 45.5 кг алтны нөөц үлдсэнэ.

Уул уурхайн зураг төслийн “Роял Рэнж” ХХК-иар техник-эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотгол хийлгэснээр уурхайн хэмжээнд ашиглалтын үеийн

**“Хавчуугийн алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө
/MV-000150/**

хаягдлыг 2%-иар тооцсон бөгөөд 754.1 мг.м³-ын дундаж агуулгатай 1.2 мян.м³ элсэнд химийн цэврээр 0.9 кг алт хаягдахаар байна. Ордын дундаж бохирдол 12.6% буюу 6.0 мян.м³ хөрс нэмэгдэхээр байна. Үйлдвэрлэлийн нөөцөөр 784.3 мян.м³ (4-С₁,12-С₁,15-С₁,16-С₁ блокуудын дээрх овоолгын 55.7 мян.м³, уурхайн хажуугаас 178.9 мян.м³, үндсэн 549.7 мян.м³) хөрс хуулж 684.0 мг.м³ -ын дундаж агуулгатай 64.6 мян.м³ элс олборлон химийн цэврээр 44.2 кг алт гарган авахаар байна.

2020 онд дээрх нөөцөөс 2-С₁, 4-С₁,12-С₁ блокуудыг бүрэн ашиглаж химийн цэврээр 23.3 кг алт олборлож химийн цэврээр 20.9 кг алтны нөөц үлдэж байсан юм.

2021 онд дээрх нөөцөөс 3-С₁ блокыг бүрэн, 15-С₁ блокын талыг ашиглаж химийн цэврээр 12.25 кг алт олборлож химийн цэврээр 13.9 кг алтны нөөцийн үлдэгдэлтэй байсан юм.

2022 онд урд онд олборлож байгаад орхисон 15-С₁ блокыг бүрэн ашиглаж дуссан бөгөөд химийн цэврээр 3.61 кг алт олборлосон юм.

2023 онд УС-27/2018-тоот гэрээний хэрэгжилтийн тайланг хянан хэлэлцэх үйл ажиллагаа хэрэгжээгүй учир ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө хянагдаж батлагдаагүй тул үйл ажиллагаа явуулаагүй болно.

ИЛ УУРХАЙ

Үйлдвэрлэлийн нөөц

2024 онд С₁-16-р блокын нөөцийг бүрэн ашиглаж 14.5 мян.м³ элс угааж 6.72 кг цэвэр алт олборлохоор УАТ-нд туссан байна.

Хүснэгт 3 Ашиглалтын системийн үзүүлэлт

| № | Ашиглалтын системийн параметр | Хэмжээ |
|----------|--------------------------------------|---------------|
| 1 | Доголын өндөр, м | 6-10 |
| 2 | Ажлын доголын налуу, град | 60 |
| 3 | Ажлын бус доголын налуу, град | 45 |
| 4 | Траншей, съездын өргөн, м | 10 |
| 5 | Траншейн налуу, % | 80 |
| 6 | Орлын өргөн, м | 25 |

Уурхайн ашиглалт

2024 онд ашиглалтын үйл ажиллагааг С₁-16-р блокын урд хэсгээс хөрс хуулалт, элс олборлолтын ажлыг эхлүүлнэ.

Үржил шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2-0.4 метрээс ихгүй зузаантайгаар бульдозероор хуулан түрж экскаватор-автосомасвалын хослолоор ашиглалтын хилийн гадна овоолж биологийн нөхөн сэргээлт хийх үед ашиглана.

Хөрс хуулалтын ажил: Ил уурхайг нээх буюу эхлэх үед С₁-16-р блокын хөрсний чулуулгийг экскаватор-автосомасвалын хослолоор өмнөх жилийн олборлолтын талбайд дотоод овоолго хийнэ. Хөрс хуулалт болон элс олборлолтын ажил хийж тухайн хэсэгт гарсан орон зайд экскаватор-автосомасвалын хослолоор дотоод овоолго хийх замаар нийт хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

**“Хавчуугийн алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө
/MV-000150/**

Элс олборлолтын ажлыг экскаватор-автосомасвалын хослолоор гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4 Уурхайн ашиглалтын саруудад олборлох хэмжээ

| № | Ажлын төрөл | Хэмжих нэгж | Ашиглалтын 4 дахь жил | | | | | 2024 он |
|---|-----------------------------------|-------------------|-----------------------|-------|-------|-------|-------|---------|
| | | | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | |
| 1 | Элс олборлолт | м ³ | | | | | 14500 | 14500 |
| 2 | Элсэн дэх алтны агуулга | мг/м ³ | | | | | 503.4 | 503.4 |
| 3 | Элсэн дэх алтны хэмжээ | кг | | | | | 7.3 | 7.3 |
| 4 | Металл авалт | % | | | | | 92 | 92 |
| 5 | Гүйцээн баяжуулалт /химийн цэвэр/ | кг | | | | | 6.72 | 6.72 |

1.1.5. Тоног төхөөрөмж

Хөрс болон элс олборлолтын ажилд өөрийн техник болох Hyundai 520LC маркийн 3.5 м³ утгуурын багтаамжтай 1ш, CAT 340D 1ш экскаватор, Norht benz маркийн 40 тн даацтай 3 ш автосамосвал ашиглана. Элсний овоолгыг түрж оруулах, хаягдал хайрга болон эфель холдуулахад 2 ш дугуйт ачигч Luigong ZL-50 ажиллана.

Хүснэгт №3.3 Ил уурхайн тоног төхөөрөмжийн иж бүрдэл / уурхайд/

| Ажлын зориулалт | Марк | Тоо, ш |
|---------------------------|---------------|----------|
| Хөрс хуулалт | Hyundai 520LC | 1 |
| Элс олборлолтод | CAT 340D | 1 |
| Хөрс болон элс тээвэрлэлт | Norht benz | 3 |
| Туслах ажилд | ZL-50 | 2 |
| Нийт | | 7 |

1.1.6. Уурхайн дотоод тээвэр

Хавчуугийн алтны шороон ордын хувьд хэвтээ уналтай тул тээвэртэй дотоод овоолготой ашиглалтын систем хэрэглэх боломжтой юм. Ашиглагдсан хоосон орон зайг хөрс болон угаах хэсгээс гарах галиар дүүргэхээр төлөвлөсөн. Ил уурхайн блокуудыг ашиглаж дууссаны дараа ашиглагдсан орон зайд дотоод овоолго үүсгэж давхар техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэнэ.

Баяжуулах хэсгээс гарсан эфель, галийг эргэн тээвэрлэж уурхайн техникийн нөхөн сэргээлтийн ажилд ашиглана. Хөрсний мөргөцгөөс 3.5м³ утгуурын багтаамжтай Hyundai 520LC экскаватораар North benz маркийн 40тн даацтай автосамосвал дээр шууд ачна. Мөргөцгийн нөхцөл, операторын ур чадвараас болон тоног төхөөрөмжийн төрлөөс хамааран экскаваторын утгуур дүүргэлт 0.9- 0.92%, автосамосвалд ачилт хийх хугацаа 2.54 мин байна. 2020 онд Hyundai 520LC экскаватор 2ш, 3ш автосамосвал ажиллахаар тооцоологдсон ба хүчин чадал сар болон ажлын эрчмээс хамааран тоног төхөөрөмжийн тоо өөрчлөгдөж болох юм.

Хүснэгт 5 Хөрс хуулалтанд ажиллах өөрөө буулгагчын тээвэрлэлтийн хугацаа

| № | Уурхайн зам | Тээвэрлэлтийн зай | Замын налуу | Замын дотоод үрэлтийн өнцөг | Чиглэл | Тээвэрлэлтийн хугацаа | Тээвэрлэлтийн хугацаа | Хамгийн их хурд | Дундаж хурд |
|------------------------|---------------|-------------------|-------------|-----------------------------|--------|-----------------------|-----------------------|-----------------|-------------|
| | | м | % | % | | % | мин | | |
| ХӨРС ТЭЭВЭРЛЭЛТ | | | | | | | | | |
| 1 | Ачитад хүлээх | - | МИН | - | - | 2.06 | 17.42 | - | - |
| | | - | МИН | - | - | 0.5 | 4.23 | - | - |

**“Хавчуугийн алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө
/MV-000150/**

| | | | | | | | | | |
|----|---------------------------------|-----|-------|-----|---------|-------|-------|------|------|
| 2 | Ачилт хийх хугацаа | - | мин | - | - | 5.63 | 47.62 | - | - |
| 3 | Экскаваторын хэсгийн зам | 50 | 0 | 3 | Ачаатай | 0.26 | 2.18 | 23.2 | 11.6 |
| 4 | Карьерын зам | 130 | 0 | 2.5 | Ачаатай | 0.24 | 2.05 | 38.7 | 32.2 |
| 5 | Траншей зам | 150 | 10.5 | 2.5 | Ачаатай | 0.5 | 4.18 | 38.7 | 18.2 |
| 6 | Үндсэн зам | 120 | 0 | 3 | Ачаатай | 0.52 | 4.43 | 23.8 | 13.7 |
| 7 | Овоолгын зам | - | мин | - | - | 0.5 | 4.23 | - | - |
| 8 | Овоолгод асгах | - | мин | - | - | 0.5 | 4.23 | - | - |
| 9 | Үндсэн зам(rev.) | 120 | 0 | 3 | Хоосон | 0.4 | 3.38 | 36 | 18 |
| 10 | Траншей зам (rev.) | 150 | -10.5 | 2.5 | Хоосон | 0.23 | 1.9 | 40.4 | 40 |
| 11 | Карьерын зам (rev.) | 130 | 0 | 2.5 | Хоосон | 0.23 | 1.97 | 40.4 | 33.4 |
| 12 | Экскаваторын хэсгийн зам (rev.) | 50 | 0 | 3 | Хоосон | 0.26 | 2.18 | 22.2 | 11.6 |
| | Нийт | 900 | - | - | - | 11.83 | 100 | - | 4.6 |

1.1.7. Овоолгын аж ахуй

Хавчуугийн алтны шороон ордын хувьд хэвтээ уналтай тул тээвэртэй дотоод овоолготой ашиглалтын систем хэрэглэх боломжтой өөрөөр хэлбэл дотоод овоолго үүсгэх, ашиглагдсан хоосон орон зайг хөрс болон хоосон чулуулгаар дүүргэх боломжтой юм. Шимт хөрсийг хуулж тусгайлан зассан талбайд 2м-ээс хэтрүүлэхгүйгээр овоолно. Шимт хөрсийг Монгол Улсын (MNS 5917:2008) стандартын дагуу түр овоолго үүсгэнэ.

Хөрсний дээд давхаргын хоосон чулуулгийг экскаватороор хуулж гадаад болон дотоод овоолгод тээвэрлэн асгаж овоолго үүсгэх бөгөөд түүнийг түрж тэгшлэх, шимт хөрсөөр хучих зэрэг техникийн нөхөн сэргээлтийг ажлыг мөн бульдозероор гүйцэтгэнэ. 2020 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд ил уурхайн хөрсийг авто тээврээр дотоод овоолгуудад овоолох ба нийт хуулах хөрсний хэмжээ 303118 м³ овоолго үүсгэнэ.

Хүснэгт 6 Бульдозерын бүтээл

| № | Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | CAT-D9 |
|---|-------------------------|-------------|--------|
| | Параметр | | |
| | Хөдөлгөөний давших хурд | | |

**“Хавчуугийн алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө
/MV-000150/**

| | | | |
|-------------------------------|---|-----------------------|---------|
| 1 | 1-р түрэлт | км/цаг | 3 |
| | 2-р түрэлт | км/цаг | 6.2 |
| | 3-р түрэлт | км/цаг | 10.1 |
| Хөдөлгөөний ухрах хурд | | | |
| 2 | 1-р ухрах | км/цаг | 3.7 |
| | 2-р ухрах | км/цаг | 7.1 |
| | 3-р ухрах | км/цаг | 10.9 |
| | Овор хэмжээ | | |
| 3 | урт | м | 5.7 |
| | өргөн | м | 3.2 |
| | өндөр | м | 3.2 |
| 4 | Хөдөлгүүрийн чадал | кВт | 248 |
| 5 | Хусуурын урт | мм | 3170 |
| 6 | Хусуурын өргөлт, буулгалт | мм | 175 |
| 7 | Масс | т | 20 |
| 8 | Хусуурын хамах чадвар | мЗ | 8.5 |
| 9 | тоо | ш | 2 |
| Бүтээлийн тооцоо | | | |
| 1 | Түрэгдэх чулуулгийн бодит эзлэхүүн | мЗ | 5.2 |
| 2 | Түрэгдэх призмийн паспортын эзлэхүүн | мЗ | 8.5 |
| 3 | Экскавацлалтын хүндрэлийг тооцох коэффициент | | 0.6 |
| 4 | Бульдозерын мөчлөгийн хугацаа | сек | 70 |
| 5 | Түрэх зай, налуугаас хамаарсан коэффициент | | 1 |
| 6 | Түрэгдэх призм дэх чулуулгийн сийрэгжилтийн коэффициент | | 1.2 |
| 7 | Техникийн бүтээл | м ³ /цаг | 202 |
| 8 | Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 12 |
| 9 | Цаг ашиглалтын коэффициент | | 0.83 |
| 10 | Ашиглалтын бүтээл | м ³ /ээлж | 2,010 |
| 11 | Хоногт ажиллах ээлжийн тоо | ш | 2 |
| 12 | Хоногийн бүтээл | м ³ /хоног | 4,019 |
| 13 | Сарын бүтээл | м ³ /сар | 112,533 |
| 14 | Жилийн бүтээл | м ³ /жил | 787,730 |

1.2. БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ

1.2.1. Баяжуулалтын технологи болон 2020 оны үйл ажиллагааны бүтээгдэхүүн гаргалт

Үйл ажиллагааны төлөвлөгөө болон техник эдийн засгийн үндэслэлийн хоёрдахь жилд элс угаан баяжуулалтын цагийн хүчин чадал нь NZMS60 маркийн цагт 50м³ элс угаах скруббер-шлюзийн хослолыг ашиглахаар төлөвлөсөн.

Хүснэгт 7 Усны хэрэглээ, баланс

2024он

**“Хавчуугийн алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө
/MV-000150/**

| | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2024 оны төлөвлөлт |
|---|---|--------------------|-------------------------------|
| 1 | Элсний хэмжээ | м ³ | 14500 |
| 2 | 1м ³ Элс угаахад шаардлагатай ус | л/м ³ | 4 |
| 3 | Технологийн усны хэрэгцээ | м ³ | 58000 |
| 4 | Үйлдвэрлэлийн цэвэр усны хэрэгцээ /30%/ | м ³ | 17400 |
| 5 | Нэгж усны төлбөр /Үйлдвэрлэлийн зориулалт/ | төг | 196.47 |
| 6 | Үйлдвэрлэлийн усны зардал | төг | 3,418.578 |

Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээнд зааснаар Хараа голын сав газрын гүний усны төлбөр 196.47 төгрөгөөр тооцсон.

1.3. ДЭД БҮТЭЦ

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь засаг захиргааны хувьд Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт харъяалагдана.

Эдийн засгийн хувьд энэхүү талбай нь уул уурхай олборлолтын дэд бүтцийн Шарын голын алтны шороон ордын зангилаанд хамаарна. Энд Шарын голын шороон ордууд болон Шарын голын нүүрсний уурхай ашиглагдаж байгаа бөгөөд Дархан хоттой төмөр замаар холбогдож мөн өндөр хүчдэлийн шугамаар холбогдсон.

Улаанбаатар хотоос 230 км зайд (үүнээс 175 км засмал зам, 55 км сайжруулсан шороон зам), Шарын голын нүүрсний уурхай ба Шарын голын төмөр замаас 8 ба 12 км зайд байрлана.

Ашиглалтын талбай орших бүс нутгийн хувьд одоогоор дэд бүтэц, эдийн засгийн хөгжлийн төлөв байдлын хувьд сайн, цаашид тухайн бүс нутгийн хувьд дэд бүтэц болон эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөв сайтай болно.

1.3.1. Уурхайн хотхон

Уурхайн хотхон нь ордын зүүн урд хэсэгт 370 м зайд 1га талбайд байрлана. Хотхон ажилчдын амьдрах байр болох 3ш контейнерэн, 3ш модон байр, захиргааны байр ажилчдын цайны газрын байр болон халуун ус, угаалгын газраас бүрдэнэ.

Засварын талбайг хотхоны зүүн урд хэсэгт 0.3 га талбайд байгуулсан бөгөөд сэлбэг, материалын агуулах, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг байрлуулсан байдаг юм. Сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн түр агуулахыг 40 тн-ийн багтаамжтай 2 контейнер ашиглан байгуулсан.

Шатах тослох материалын агуулах нь торон хашаагаар хүрээлэгдсэн задгай талбайд уурхайн хотхоноос баруун хойш 150 метрээс доошгүй зайд байрладаг. Энд 100-200 литрийн багтаамжтай төмөр торхтой тосолгооны материал, масло болон уурхайн 7-10 хоногийн ажлыг хангах хэрэгцээний түлшний багтаамж бүхий 60тн-ий

ёмкость, шатахуун түгээгүүр байрладаг юм. Уурхайн ажиллагсдын 40 тн-ийн контейнерыг ахуйн зориулалтаар бүрэн тоноглогсон байранд байрлуулах бөгөөд 1 контейнерт 8 хүн байрлана. Контейнер хаус нь агууржуулагч болон кондейшн зэргээр тоноглогдсон байна.

Мөн уурхайн тосгонд сагс волейболын талбай байх ба энэ нь амарч байгаа ажиллагсад биеийн тамираар хичээллэх боломжийг бүрдүүлэн ажиллахаар төлөвлөсөн.

1.4. 2024 онд хийгдэх ажлын хэмжээ

2024 онд С₁-16-р блокын 0.51 га газар уулын ажлаар олборлолтод өртөгдөх ба мөн өмнөх онуудад эвдрэлд өртсөн В-4-р блокын 6.19 га нийт 6.7 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээс энгийн хамгаалалтын бүсд 4.4 га, энгийн хамгаалалтын бүсийн гадна 2.3 га, 2022 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн 5.3 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийхээс энгийн хамгаалалтын бүсд 4.5 га, энгийн хамгаалалтын бүсийн гадна 0.8 га-д явагдана. Нөхөн сэргээлтийн ажил болон байгаль хамгаалах зардалд 189.54 сая.төгрөг төлөвлөсөн. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтэнд 170.5 сая.төгрөг. Байгаль орчин хамгаалах зардал 19.04 сая.төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Цаг уур, уур амьсгалын үзүүлэлтүүд

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын уур амьсгалын үндсэн нөхцлийг тодорхойлохын тулд тус суманд орших цаг уурын станцын 1990-2017 он хүртэлх сүүлийн 27 жилийн мэдээг ашиглан боловсруулсан болно.

Уур амьсгалын улирлын ерөнхий горим: Дархан-Уул аймгийн уур амьсгалын ерөнхий мужлалыг үйлдэхдээ таримал ба хадлан бэлчээрийн ургамлын ургах үеийн чийг, дулааны үзүүлэлтийг үндэс болгодог. Тус сумын нутаг нь уур амьсгалын мужлалын хувьд чийглэгдүү хүйтэн мужид хамаарч байна. Нарны нийлбэр цацраг 1300 кВт цаг/м² -аас бага буюу нийлбэр цацрагаар Монгол орны бага бүсэд оршдог. Хоногийн дундаж температур +10°C-аас дээш байх өдөр 135 байдаг.

Нар гийгүүлэх нийт хугацаа 2700 цагаас бага бөгөөд өвлийн өдөр 5 цаг, зуны өдөр 9 цаг орчим үргэлжилнэ. -40°C ба түүнээс хүйтэн температуртай өдөр 4 байдаг бол +30 °C-аас халуун байх өдөр 13 өдөр байна.

Агаарын температур: Дархан-Уул аймаг орчмын нутгаар сүүлийн 30 жилийн хугацаанд агаарын температурын жилийн дундаж -1.9 градус хүйтнээс +3.2 градус дулаан байдаг байна. 1984-1988,1991,1996, 2005, 2010, 2012 онуудад агаарын температурын жилийн дундаж утга хасах градустай, бусад онуудад нэмэх градустай байдаг.

Агаарын температурын УАД-нь 0.7 градус дулаан, хамгийн их нь 1999 онд 44.5 градус /Шарынгол суманд 7 сард / хүрч халсан, хамгийн бага нь 2001 онд -48.5 градус /Шарынгол суманд 1 сард / хүрч хүйтэрсэн байна. Жилд дунджаар 220-230 өдөр хүйтрэлтэй байж бусад хугацаанд дулаан байдаг. УАД-аар хаврын эцсийн цочир хүйтрэл агаарт 5 дугаар сарын III-10 хоногт, намрын эхний цочир хүйтрэл 9 дүгээр сарын II-10 хоногт ажиглагддаг.

Нарны цацраг: Дархан-Уул аймгийн Шарынголсумын шохойн орд орчны өргөрөгт нарны цацраг байгалийн гэрэлтүүлэг “хүрэлцээтэй” мужид хамаарагдана. Жилдээ 4360 мДж/м² нийлбэр, 2411 мДж/м² шууд цацраг ирж агаар, хөрс, газрын гүний дулаан хүйтний горимыг бүрдүүлэх нэгэн хүчин зүйл болдог.

Өвлийн саруудад 104-155 мДж/м² нийлбэр цацраг ирдэг бол зуны саруудад үүлшил ихэвчлэн 3-7 балл хүрдэг ч 500-650 мДж/м² хэмжээтэй өвлийнхөөс 2 дахин их цацраг ирдэг нь нарны өндөр ихэссэнтэй уялдаж ихээхэн дулааны илч бий болгож халдаг.

Хөрсний гадаргад цацрагийн тэнцэл 11-2 дугаар саруудад сөрөг тэмдэгтэй буюу цацрагийн алдагдал дутагдалтай -30...-175 мДж/м² байхад бусад саруудад эерэг буюу цацрагийн орлого ихтэй нарны өндөр их байдаг. Дулааны саруудад 2704-330 мДж/м² болж ихээхэн дулаан хөрс чулуулагт нэвчиж байхаас гадна нарны илч түүний чанарт хүртэл нөлөөлж болно.

**“Хавчуугийн алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө
/MV-000150/**

Нарны гийгүүлэл орд орчимд жилдээ 2530 цаг гийгүүлж хоног, сарын хуваарилалт явц нь нарны өндөр цаг улирал, үлшил зэргээс хамаарна. Зуны саруудад 260-310 цаг, өвлийн саруудад 145-195 цагийн гийгүүлэлтэй байдаг. Нэг хоногт өвөл 6-7 цаг, зун 9-10 цаг гийгүүлнэ.

Дулаан улиралд нарны цацраг, гийгүүлэл их байдгийг харгалзаж Шохойн болон үйлдвэрлэлийг эрчимтэй явуулж шохойн чулуу олзворлолт гаргалт, хөрс хуулалтыг эрчимтэй зохистой хийж ажиллах уур амьсгалын нөөц ихтэй. Харин зарим өдөр нарны хэт халалтаас бүгчим халуун, гадаа ажиллахад нарших зэрэг тохиромжгүй нөхцөлөөс ажилчдын хөдөлмөрийн чадвар доройтох, уулын машин техник, үйлдвэрлэлийн ажиллагаанд түр саатал гарч болно.

Хур тунадас: Дархан-Уул аймгийн Шарынгол сумын орчны агаар мандлын хур тунадас, агаарын чийгшил нь орчныг цэвэршүүлж хөрсний ба гүний усны түвшнийг тодорхойлж байхаас гадна шохойн чулууны, түүнийг олборлож ачих тээвэрлэх, үйлдвэрт буулгах, хадгалалт хамгаалалт, зөөж тээвэрлэх, чанарт зохих хэмжээний нөлөө болж байдаг. Энэ бүс нутагт жилдээ 250-300 мм хур тунадас орж байдгийн 90.5% гаруй нь зөвхөн дулааны улиралд орно. Өндөрлөг уул өөд хур тунадасны хэмжээ нэмэгдэж байдаг.

Ялангуяа зуны 3 сард нийт тунадасны 67 % нь ордог бөгөөд бороо цасанд чийг нь нэмэгдэж зуны зарим үед их борооны улмаас үерийн нөхцөл бүрдэж ихээхэн ус үер уурхайн карьерт хуримтлагдах тохиолдол байдаг байна.

Энэ бүс нутагт жилийн дулаан улиралд 35-45 өдөр бороо, 5-10 өдөр мөндөртэй аадар бороо орж нэг хоногийн дотор аль ч сард тухайн сарын хэмжээнээс хэтэртэл цас, бороо унахаас хамгийн их нь 50-86 мм бороо орсон нь 7 дугаар сарын хэвийн хэмжээнээс 50% их байна.

Хүйтэн улиралд 30-35 өдөр цас орж дунджаар 10-13 см зузаантай, 0.17-0.24 г/см³ нягтардаг. Хавар намрын шилжилтийн цагаар 1-2 өдөр нойтон цас их хэмжээтэй унадаг.

Тогтвортой цасан бүрхүүл өмнөх жилийн 11 дүгээр сарын 28-наас тогтож, дараа жилийн 3 дугаар сарын 20-оор ханзарч 120-150 хоногт хадгалагддаг.

Чийгшил: Агаарын харьцангуй чийгшил агаарын температурын эсрэг явцтай, жилдээ 65% байдаг нь манай орны чийглэгдүү нутгийн нэг юм. Харьцангуй чийг өвлийн саруудад хамгийн их 70-80 %, дараагийн их хэмжээ зуны саруудад 55-64 % хамгийн бага хэмжээ хавар 35-45 %, 2 дахь бага хэмжээ намар 40-50 % болж “тохиромжтой”, уул уурхай болон техник технологид ихэвчлэн “чийглэгдүү” нөлөө үйлчлэлтэй байна.

Салхины горим: Хавчуугийн алтны шороон орд орчмын нутаг өвөлд эсрэг циклонлог цаг агаартайгаас салхи намуун салхигүй үе олон давтагдалтайгаар агаар мандлын их даралтын орны нөлөөнд оршино. Дулаан улиралд циклонлог цаг агаар, агаар мандлын фронтын үйлчлэл идэвхжиж цаг агаар хямарч, үлшил нэмэгдэж, хур тунадасны зонхилох хувь унадаг.

Агаар мандлын энэ нөхцөлийн улмаас орон нутгийн салхи, шуурганы үйлчлэл бий болдог. Салхины ноёлох чиглэлийг улирлын төв саруудаар авч үзвэл энэ бүсэнд өвлийн саруудад ялангуяа Дархан хотын үйлдвэрийн хэсэгт Хараа голын сав

газрын өмнө чиглэлүүдийн, хаврын саруудад баруун хойноос зүүн хойд, зуны саруудад баруун өмнөөс зүүн хойд чиглэлүүдийн, намрын улиралд баруун өмнөөс зүүн хойд чиглэлүүдийн давтагдал 9.4-29 % ноёлж байдаг. Харин алтны шороон орд орчинд энэ ерөнхий ноёлол зарим сар, улиралд хувирамтгай болдог. Дарханы үйлдвэрийн орчноос салхи задгай салхилж байдгаас ноёлох чиглэл Дархан хотын хэсгээс ялгагддаг.

2.2. Газрын гадарга, хэвлийн тогтоц, онцлог

2.2.1. Геологийн тогтоц, давхрага зүй

Хавчуугийн алтны орд нь Хойд Хэнтийн алтжилтын мужлалд багтах бөгөөд шороон ордын төрөлд хамаарна. Геологийн тогтцын хувьд энэ талбайд Дөрөвдөгч галавын голын хөндийн сэвсгэр хурдас болон Протерозой, Палеозойн үндсэн чулуулаг тархсан байна. Үүнд:

Дөрөвдөгч галавын хурдас(Q). Энэ хурдас нь 5-30м зузаантай аллювийн (alQ) гаралтай элс, элсэнцэр, бага зэргийн бул чулуугаар(10% хүртэл) чигжигдсэн хайрга, шавранцар болон элювийн(eQ) 3м зузаантай элснээс тогтох бөгөөд алтны шороон ордын үндсэн эх үүсвэр юм. Орд газар нь геологийн тогтцын хувьд алт агуулагч элсний хоёр үетэй бөгөөд дээд үе-балансын бус, доод үе-балансын гэж геологичид тогтоожээ.

Палеозойн хурдас(PZ). Энэ хурдсыг голчлон боржин, гранидиорит бүрдүүлж байна. Энэ нь алтны шороон ордын аллювийн хурдсын доод хэсэгт үндсэн чулуулаг хэлбэрээр тогтох бөгөөд энэ чулуулгийн дээд хэсэг нь ан цавтай, алт агуулсан кварцан судалтай.

2.2.2. Геоморфологи

